

АГУУЛГА

БҮЛЭГ 1.ОРШИЛ	3
БҮЛЭГ 2.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
2.1. Төслийн нэр	4
2.2. Төсөл хэрэгжүүлэгч	4
2.3. Төслийн байршил	4
2.4. Хүчин чадал	6
2.5.Химийн бодисын хэрэглээ	6
2.6.Энгийн тэсрэх бодисын үйлдвэр.....	6
2.7.Тэсрэх материалын агуулах	7
2.8.Захиргаа аж ахуйн барилга.....	8
2.9.Үйлдвэрийн лаборатори.....	8
БҮЛЭГ 3.ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	11
3.1.Газрын гадарга, байр зүй	11
3.2. Уур амьсгалын онцлог.....	11
3.3. Усан орчин	12
3.4. Хөрс.....	12
3.5. Ургамал.....	12
3.6. Амьтан	12
3.7. Нийгэм эдийн засаг	13
БҮЛЭГ 4.ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	14
БҮЛЭГ 5.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	18
БҮЛЭГ 6.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
6.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	21
6.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	23
6.3. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	24
6.4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	24
6.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	27
6.6. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	28
6.7. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө	29
6.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	29
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ	31
ДҮГНЭЛТ	32

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ 33

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	4
Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбилцол	4
Хүснэгт 3. Нийт хүчин чадал.....	6
Хүснэгт 4. Хэрэгцээнд шаардагдах химийн бодисын хэмжээ, эх үүсвэр.....	6
Хүснэгт 5. Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийг нөлөөллийн хэлбэр, нөлөөллийн чанар, үргэлжлэх хугацаа нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь.....	14
Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	21
Хүснэгт 7. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	23
Хүснэгт 8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	24
Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	27
Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	28
Хүснэгт 11. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө	29
Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	29
Хүснэгт 13. 2024 оны БОМТ-нд зарцуулах нийт зардал	31

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын байршлын зураг	5
Зураг 2. “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын харагдах байдал	5
Зураг 3. Энгийн тэсрэх бодисын үйлдвэрлэлт	7
Зураг 4. Тэсрэх материал, түүхий эдийн агуулах	7
Зураг 5. Аж ахуйн хэсгүүд	8
Зураг 6. Үйлдвэрийн хяналтын лаборатори.....	9
Зураг 7. Тусгайлан тоногдсон туршилтын талбай	10

БҮЛЭГ 1. ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

БОМТ-ний тайлан боловсруулах аргачлал:

“Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг боловсруулахдаа байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байгууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

“Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын төслийн БОМТ-нд 2024 онд нийт **3,298,000** төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		
	1	Аж ахуйн нэгжийн нэр	“Мастер майнинг сервис” ХХК
2	Регистрийн дугаар	5889782	
3	Төслийн нэр	“Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын төсөл	
4	Төслийн байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Улаанбаатар хот
5		Сум/Дүүрэг	Багахангай дүүрэг, 2-р хороо
6	Газар ашиглалтын зориулалт		
7	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар хот
8	хаяг	Сум/Дүүрэг	Хан-уул дүүрэг
9		Баг/Хороо	15-р хороо, Эм Эн Эс Бюлдинг ХХК-ийн байр
10	Захирлын хаяг	Нэр	Захирал Б.Баярбат
11	хаяг	Гар утас	976-88889094

2.1. Төслийн нэр

“Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын төсөл

2.2. Төсөл хэрэгжүүлэгч


“МАСТЕР МАЙНИНГ СЕРВИС” ХХК

2.3. Төслийн байршил

Үйлдвэр, агуулахын талбай нь Улаанбаатар хотоос зүүн урагш 90 км, Багахангай дүүргээс зүүн зүгт 3км зайд байрлалтай байна. Тус талбайн булангийн цэгийн солбицолыг хүснэгтээр үзүүлээ.

Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбилцол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	107	31	33.62	47	22	21.32
2	107	31	40.02	47	22	23.13
3	107	31	43.73	47	22	17.21
4	107	31	37.19	47	22	15.32



Зураг 1. “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын байршлын зураг



Зураг 2. “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын харагдах байдал

2.4. Хүчин чадал

Уурхайн зориулалттай тэсрэх бодисын үйлдвэрийн хүчин чадлыг төсөл захиалагч байгууллагын техникийн даалгавар, одоогийн бэлтгэгдэж байгаа болон хүлээгдэж байгаа зах зээлийн багтаамж, төсөл хэрэгжүүлэгчийн ханган нийлүүлэлт хийж буй гэрээт байгууллагуудын хэрэгцээнд тулгуурлан тодорхойлсон болно. Мөн тус үйлдвэр агуулахын цогцолборын талбайд тэсрэх бодис тэсэлгээний хэрэгслийн агуулахуудыг барьж байгуулсан ба нэмэлтээр түүхий эдийн 2 агуулахыг тус бүр 300 тн хүчин чадалтайгаар барихаар төлөвлөж байна.

Хүснэгт 3. Нийт хүчин чадал

№	Үйлдвэрүүд	Хэмжих нэгж	Хүчин чадал
1	Энгийн найрлагат тэсрэх бодис /АНФО/ үйлдвэр	тн/жил	5000
2	Түүхий эдийн агуулах	тн	60
3	Тэсрэх бодисын агуулахын багтаамж	тн	13
4	Тэсрэх хэрэгслийн агуулахын багтаамж	тн	13
5	Тэсэлгээний өдөөгчийн агуулахын багтаамж		17

2.5.Химийн бодисын хэрэглээ

Тэсрэх бодисын үйлдвэрийн технологит доорх нэр төрлийн химийн бодисуудыг ашигладаг. Аммоны нитрат (аммиакийн шүү), дизелийн түлш, хөнгөн цагааны нунтаг зэрэг химийн бодисыг үйлдвэрийн технологийн үйлдвэрлэл буюу бүтээгдэхүүний найрлагын түүхий эд байдлаар ашигладаг.

Хүснэгт 4. Хэрэгцээнд шаардагдах химийн бодисын хэмжээ, эх үүсвэр

№	Монгол нэр	Олон улсын нэр	Томьёо	Нийлүүлэлт	Хэмжээ
1	Аммиакийн шүү	Ammonium nitrate	NH ₄ NO ₃	Импортоор	4700 тн
2	Дизелийн түлш	Diesel fuel	-	Дотоодын зах зээл	308 тн
3	Хөнгөн цагааны нунтаг	Aluminium	Al	Импортоор	50 тн
4	Ашигласан тос	Oil	-	Дотоодын зах зээл	50 тн

2.6.Энгийн тэсрэх бодисын үйлдвэр

Энгийн найрлагатай тэсрэх бодисын үйлдвэр нь жилд 5000тн тэсрэх бодис үйлдвэрлэх хүчин чадалтай байх бөгөөд үйлдвэрийн Tread T-1 маркийн тоног төхөөрөмжийг 10x8 метр хэмжээтэй сандвичэн барилгад суурилуулахаар төлөвлөсөн ба үйлдвэрийн байр дотор 10 м³ багтаамжтай дизель түлшний танкийг хамт байрлуулахаар төлөвлөж байна.

Тус үйлдвэрийн байршлыг сонгохдоо үндсэн түүхий эд аммиакийн шүүний агуулахтай харьцангуй ойр байрлуулахаар төлөвлөсөн ба мөн бэлэн бүтээгдэхүүн хадгалах агуулах хүртэлх зайг агуулахын аюулгүйн зайг үндэслэн тооцсон. Үйлдвэр нь энгийн тэсрэх бодисыг тухайн газрын чулуулгийн хатуулаг, орчны шинж чанарт тохируулан Энгийн буюу "ROCK MASTER", Хүчитгэсэн буюу "ROCK MASTER-X", гэсэн 2 төрлөөр

үйлдвэрлэж, полиэтилен дотортой, полипропилен гадартай давхар уутанд 25 кг-аар шуудайлан савлаж байна.



Зураг 3. Энгийн тэсрэх бодисын үйлдвэрлэлт

2.7.Тэсрэх материалын агуулах

Үйлдвэрийн агуулахууд нь түүхий эд, туслах материалын, импортын эмульсийн тэсрэх бодисын, тэсрэх хэрэгслийн, бүтээгдэхүүний (ANFO) гэж ангилагдах бөгөөд агуулахын хамгийн их багтаамж нь (аммиакийн шүү орохгүйгээр)-60 тн, тэсрэх бодис-50 тн, тэсэлгээний хэрэгсэл-26 тн хадгалах хүчин чадалтай.

Багахангайн тэсрэх бодис, түүхий эд материалын агуулахуудыг ТААНД-ийн шаардлагын дагуу тоноглон бөгөөд эдэлбэрийн зүүн хэсгийг шороон далангаар тусгаарлан, аянга зайлуулагчаар аянгаас хамгаалсан хоёр хоёроор нь зэрэгцүүлэн барьсан агуулахуудад хадгалдаг.



Зураг 4. Тэсрэх материал, түүхий эдийн агуулах

2.8.Захиргаа аж ахуйн барилга

Тус үйлдвэр агуулахын талбайд оффисын болон ажиллагсадын хувцас солих, түр амрах, ажлын хурал хийх, лабораторийн өрөө гэх хуваалт хийгдсэн өрөөнүүдийг ашиглахаар төлөвлөсөн. Үйлдвэр агуулахын цогцолбор нь харьцангуй гар ажиллагаа багатай тул үйлдвэрт ажиллах хүний нөөц үүнийг дагаад цөөн байна. Тиймдээ ч ажилчдын хувцас солих өрөө болон захиргааны ажилчдын оффисыг нэг барилгад багтаан барьж байгуулахаар төлөвлөөд байна.

Мөн үйлдвэрийн байр, бэлэн бүтээгдэхүүний болон түүхий эдийн агуулах, оффисын барилга зэрэг шаардлагатай газруудад 12 ширхэг хяналтын камер байрлуулан интернетийн сүлжээтэй байрлалаас 24 цагийн турш хянаж байна.



Зураг 5. Аж ахуйн хэсгүүд

2.9.Үйлдвэрийн лаборатори

Лаборатори нь энгийн найрлагатай тэсрэх бодисын суурин үйлдвэр агуулахын цогцолборт ажилчдын оффисын байрны хажууд зэрэгцээгээр байгуулах ба 40 тн-н контейнерийг лабораторийн зориулалтаар тохижуулж тоноглон ашиглана.

Лабораторийн байр нь агаар сэлгэгчээр тоноглогдсон байх ба байгалийн гэрэлтүүлэг сайтай байхаар цонх гаргасан байна. Лаборатори нь үйлдвэрлэлийн процесс, түүхий эдүүдийн шинж чанар болон үйлдвэрийн бэлэн бүтээгдэхүүн тэсрэх бодисын шинж чанарын үзүүлэлтийг хянах зориулалттай.

Үйлдвэрийн технологийн оператор нь анхдагч түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүн тэсрэх бодисын шинж чанарын үзүүлэлтэнд хяналт тавьж туршилт шинжилгээний ажлыг гүйцэтгэж байх ба лаборатори нь үйлдвэрийн үйл ажиллагаатай уялдаж ажиллана. Лабораторит дараах шинжилгээнүүд хийгдэнэ.Үүнд:

- Тэсрэх бодисын шингээх чадварыг тодорхойлох,
- Мөхлөгийн бүтцийг тодорхойлох,
- Нягтыг тодорхойлох,

-Бутрамтгай чанарыг тодорхойлох,

-Чийглэг тодорхойлох.

Лабораторийн байранд нэг химич инженер үйлдвэрийн ажиллах цагийн хуваарийн дагуу ажил гүйцэтгэх ба үйлдвэрээс гарах тэсрэх бодист хийх шинжилгээ болон түүнд орж буй түүхий эдийн шинж чанарт байнгын хяналт шалгалт хийж ажиллана.

Лаборатори нь тэсрэх бодисын шинж чанар болон түүхий эдүүдийн хяналтын шинжилгээг тогтмол явуулах ба угаалтуур болон дараах тоног төхөөрөмжийн иж бүрдэл бүхий лабораторийн ширээ суурилагдана.



Зураг 6. Үйлдвэрийн хяналтын лаборатори

Үйлдвэрээс гарсан бүтээгдэхүүн /тэсрэх бодис/-ийн туршилтын ажлыг явуулахдаа зориулалт бүхий тусгайлан зассан далан болон хашаагаар хүрээлэгдсэн талбай бүхий цэгийг байгуулна. Энд тэсрэх бодисын чанар, тэсрэлтийн хүч зэргийг тодорхойлох туршилтын бага хэмжээний тэсэлгээ хийгдэх тул энэ нь үйлдвэрийн бүс дэх онцгой объектуудын нэг юм.

Туршилтын талбайд 3м радиустай, өндөр нь 3м хэмжээтэй ёмкостыг хагас далдлан булж дотоод орон зайд нь газрын гадаргатай ижил түвшинд хүртэл нь шороогоор дүүргэх ба ёмкостыг агаарын цохилтын долгион, дуу чимээ гадагшилж байхаар хэд хэдэн дээш харсан яндан гарган нүхлэнэ. Туршилтын талбай нь шалган нэвтрүүлэх байрнаас 60 метр зайд, Аммиакийн шүүний агуулахаас-150 метр, ТБ-ын агуулахаас 115 метрийн зайд байрлана. Тус объектийг дараах байдалтайгаар байгуулахаар төлөвлөж байна.



Зураг 7. Тусгайлан тоногдсон туршилтын талбай

БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3.1. Газрын гадарга, байр зүй

Улаанбаатар хот нь Монгол орны физик газар зүйн мужлалаар Хангай Хэнтийн уулархаг их мужийн хэсэгт байрладаг байна.

МУ-ын нийслэл Улаанбаатар хот нь 1.3 сая хүн амтай. Улаанбаатар хот нийт 4,700 квадрат км (Монгол улсын нутаг дэвсгэрийн 0.3%) талбайтай бөгөөд 9 дүүрэгт хуваагдаж тэдгээр дүүрэг нь цаашдаа 152 дэд дүүрэг (хороо)¹ буюу хороо болж хуваагддаг. Хороо нь хэсгүүдээс бүрддэг.

Нийслэлийн хотын хамгийн өмнө захын цэг нь Төв аймгийн Сэргэлэн сумтай хиллэж байгаа хойд өргөрөгийн 47°37'30", зүүн уртрагийн 107°18'54"-ын солбицолд, баруун захын цэг нь Төв аймгийн Баянчандмань, Батсүмбэр сумтай хиллэж байгаа зүүн уртрагийн 107°23'12", хойд өргөрөгийн 48°16'42"-ын солбицолд, хойд захын цэг нь Төв аймгийн Батсүмбэр сумтай хиллэж байгаа хойд өргөрөгийн 48°16'00", зүүн уртрагийн 106°27'-ын солбицолд, зүүн захын цэг нь Төв аймгийн Эрдэнэ сумтай хиллэж байгаа зүүн уртрагийн 107°37'24", хойд өргөрөгийн 47°53'-ын солбицолд оршино.

3.2. Уур амьсгалын онцлог

Нарны цацраг: Төслийн район орших бүс нутаг нь уртрагийн дагуу сунаж тогтсон хойноос өмнө рүү цацраг, нарны гийгүүлэл нэмэгддэг зүй тогтолтой. Бүс нутагт дунджаар хэвтээ гадаргад 4686 мДж/м², шууд цацраг 2621 мДж/м² ирнэ. Нарны цацрагийн дулааны баланс жилдээ 1657 мДж/м² байх бөгөөд өвлийн саруудад -23 - -31 мДж/м² алдагдалтай, бусад саруудад эерэг илүүдэлтэй байна.

Агаарын температур: Эх газрын эрс тэс уур амьсгалын нөхцөлөөс шалтгаалан өвөл нь харьцангуй хүйтэн, зундаа халуун байдаг. Сарын дундаж температур 1 дүгээр сард -27.4°C ба 7 дугаар сард 17.1°C байдаг. Хамгийн өндөр температур 7 дугаар сард 39°C хүрч, 1 дүгээр сард -40°C хүрч хүйтэрдэг байна.

Агаарын чийгшил: Төслийн талбайд жилийн дундаж харьцангуй чийгшил 70-75% хүрч хамгийн хуурай хаврын улиралд 45-55% байна. Энэ бүс нутагт хуурай өдөр тохиолдож байхад 30-40 өдөр 80%-иас илүү их чийгтэй байдаг. Хур тунадас жилдээ 350-450мм, зарим жил үүнээс ч их, мөн зарим жил бүр бага ордог онцлогтой. Хур тунадасны 95-97% нь дулааны улиралд 75-80% нь зуны 3 сард ордог ерөнхий зүй тогтолтой. Хур борооны хамгийн их эрчим 1.5мм/мин, дунджаар 0.02-0.04 мм хүрдэг нь усархаг бороотой гэсэн үг юм. Хур борооны төрөл аадар, зүс, шиврээгээр ялгагддаг боловч 1км² талбайд 6-8 удаа аянга ниргэлт өгч, 30-40 өдөр аянгатай, 60-70 цаг үргэлжилж (тах 130 цаг орчим) нэг аянга 105-230 минут үргэлжилнэ.

Салхи: Улаанбаатар хот орчимд салхины дундаж хурд 1.3-4.8 м/сек буюу 2.7 м/сек байдаг. Улирлын хувьд, салхины хурд хаврын улиралд 1.9-6.5 м/сек, өвлийн улиралд 0.7-2.8 м/сек, бусад улиралд 1.2-5.5 м/сек тус тус байдаг байна.

Хур тунадас: Чингэлтэй дүүрэгт сарын дундаж хур тунадас 296 мм ба 274 мм тус тус байдаг байна. Өндөр уулсын бүс нутагт хур тунадас 403 мм хүрдэг байна.

3.3. Усан орчин

Гадаргын ус: Улаанбаатар хот нь гадаргын ус зүйн сүлжээний хувьд Хойд мөсөн далайн ай савын Туул голын сав газарт оршино. Улаанбаатар хотоор Туул гол урсан өнгөрдөг. Төслийн талбайн ойр орчимд хамгийн ойр оршиж байгаа нь Сэлбэ гол юм.

Газрын доорх ус: Тухайн бүс нутгийн шинж төрхтэй гидрогеологийн нөхцөлийг илэрхийлж буй газрын доорхи усны тархалт, бүрэлдэн тогтолтын ерөнхий байдал болон геологийн тогтоцын өвөрмөц онцлогыг үндэслэн, судалгааны дэвсгэр талбайн хүрээнд гидрогеологийн давхарга зүйн хувьд дараах биеэ даасан уст үе давхарга, газрын доорхи усны бусад хуримтлал, бөөгнөрлийг ялгаж байна. Үүнд:

1. Аллювийн гарал үүсэлтэй орчин үеийн сэвсгэр хурдасны зузаалаг дахь уст үе давхарга.
2. Доод-дунд девоны настай бялхмал-тунамал чулуулгийн массив дахь алаг цоог тархалттай газрын доорхи ус.

3.4. Хөрс

Улаанбаатар хот нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалын хувьд Хангайн их мужийн өндрийн бүсшилтэй нутгийн Хэнтийн дэд бүсийн хүрээнд Хэнтийн төвийн хөрсний тойрогт хамаарагдана (Үндэсний атлас, 2009).

3.5. Ургамал

Судалгааны талбай нь ургамал газарзүйн мужлалаар Евро-Азийн хээрийн их муж, Дагуур Монголын (Төв Азийн) дэд их муж, Дагуур-Монголын уулын ойт хээрийн муж, Орхон-Сэлэнгийн дэд мужид хамаарагдана (БНМАУ-ын үндэсний атлас, 1990 он).

3.6. Амьтан

Амьтны аймгийн хувьд Улаанбаатар хот орчмын нутаг дэвсгэрийн хэсэгт амьтны аймгийн төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно. Энэ нь Улаанбаатар хотын ойр орчмын хүн амын нягтшил, аж ахуйн хөгжил, замын хөдөлгөөнтэй холбоотой. Тухайлбал шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн (*P.domesticus*) ба хээрийн (*P.montanus*) бор шувуу, хөхвөр тагтаа (*C.livia*), Сохор элээ (*Milvus migrans*), Шаазгай (*Pica pica*), Улаан хошуут (*Pyrhcorax pyrrhcorax*), Хар хэрээ (*Corvus corone*), Хон хэрээ (*Corvus corax*) арай илүүтэй үзэгдэнэ. Хөхтний

дотроос дагуур зурам, хэргэлзий оготно, үлийн цагаан оготно, гэрийн хулгана нутагшиж байна. Шавьжийн ангиас голдуу төрөл бүрийн цохын овог тааралдана.

3.7. Нийгэм эдийн засаг

Багахангай нь Улаанбаатар хотын 9 дүүргийн нэг юм. 2 хороодод хуваагддаг. Хүн ам нь 2008 оны байдлаар 3,864 бөгөөд 140.0 км² газар нутагтай.

Багахангай дүүрэг нь анх 1989 онд Улаанбаатар хотын Багахангай хороо болон байгуулагдаж, улмаар нийслэлийн алсагдсан дүүрэг болон өргөжиж, засаг захиргааны 2 хороотой 750 шахам өрхийн 3645 хүн амтай. Нийт малын тоо 10774.

Багахангай дүүрэг нь монгол улсын нийслэл Улаанбаатраас зүүн урагш 90км-т, далайн түвшнээс дээш 1614 метр өргөгдсөн 14 мянган км² нутаг дэвсгэртэй, баруун хойд талаараа Төв аймгийн Сэргэлэн сум, зүүн болон урд талаараа Баян сумтай хил залган оршдог. Нийслэлийн алслагдсан дүүргүүдийн нэг юм.

Тус дүүрэгт төсөвт байгууллага 14, нийслэлийн өмчийн үйлдвэрийн газар 4, ХХК11, хоршоо 2, нөхөрлөл 2 нийт 33 байгууллага, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж, татварын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн төлөвлөгөөг бүрдүүлж байна.

Багахангай дүүрэг нь Улаанбаатар хоттой 107 км төмөр замаар, 90 км хатуу хучилттай хар замаар холбогдсон бөгөөд төмөр замын өртөөнд төмөр замаар жилдээ 15,0-16,4 тонн ачаа тээвэрлүүлж, транзит ачаа 3.7-4.1 сая тонныг дамжин өнгөрүүлж дунджаар сая орчим зорчигч дайран өнгөрдөг 2-р зэрэглэлийн өртөө юм.

Дүүргийн эрчим хүчний гол эх үүсвэр нь цахилгаан эрчим хүч бөгөөд төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон 35.0 кв-ын 200.0 км урт цахилгаан дамжуулах шугамтай, 2500 квт-ын хүчин чадалтай 4-н дэд станц эзэмшин эрчим хүчээр жилдээ 160 сая төгрөгийн борлуулалт хийж байна.

БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Мастер майнинг сервис” ХХК–ийн “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын үйл ажиллагаагаар байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийг “Леопольдын матрицын” аргаар тодорхойлов. Леопольдын матрицын аргыг байгаль орчны үнэлгээнд түгээмэл хэрэглэгддэг ба экспертийн үнэлгээг Фишер, Девис нарын гаргасан² / нөлөөллийн чанар (+,-), нөлөөллийн зэрэг (1-5), нөлөөллийн үргэлжлэх хугацаа (Б,У)/ хувилбараар тодорхойллоо.

Хүснэгт 5. Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийг нөлөөллийн хэлбэр, нөлөөллийн чанар, үргэлжлэх хугацаа нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь

№	Матрицын утга Байгаль орчны үзүүлэлт	Нөлөөллийн чанар			Нөлөөллийн зэрэг					Нөлөөллийн үргэлжлэх хугацаа		
		Зерэг (+)	Сөрөг (-)	Нөлөөгүй (0)	1	2	3	4	5	Урт	Дунд	Богино
Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт												
1	Гадаргын усны чанарын өөрчлөлт			x								
2	Гадаргын усны нөөц хомсдох			x								
3	Гүний усны нөөц хомсдох			x								
4	Ургамлын бүтцийн өөрчлөлт		x				x				x	
5	Хөрсний элэгдэл, эвдрэл		x				x				x	
6	Геологийн тогтоц өөрчлөгдөх, ашигт малтмалын нөөц хомсдох			x								
7	Зэрлэг амьтадын орон зайн өөрчлөлт			x								
8	Уур амьсгалын өөрчлөлт			x								
Байгалийн нөөцийн ашиглалт												
1	Газрын гадаргын нөөц баялаг		x				x					x
2	Бэлчээр, тэжээлийн байдал			x								
3	Эрдэс, түүхий эдийн нөөц			x								
4	Эрчим хүчний нөөц			x								

Байгаль орчны өөрчлөлт											
1	Ундны усны чанар өөрчлөгдөх			x							
2	Урсгал усны нөөцийн горим			x							
3	Агаарын бохирдол		x			x					x
4	Хөрсний бохирдол		x			x					x
5	Ургамлан бүрхэвчийн хомсдол		x				x				x
6	Дуу чимээ, шуугианы нөлөөлөл		x			x					x
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл											
1	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	x					x				x
2	Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх			x							
3	Хүн амын эрүүл мэнд		x			x					x
4	Хүн амын орлого нэмэгдэх	x				x					x
Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл											
1	Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх			x							
2	Ландшафтын хэлбэр, өнгө төрх өөрчлөгдөх			x							
3	Тусгай хамгаалттай ба цогцолбор газарт нөлөөлөх			x							
4	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх			x							
5	Археологи, палентологийн олдворт нөлөөлөх			x							
Эдийн засаг											
1	Татварын орлого өөрчлөгдөх	x				x					x
2	Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x					x
3	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x					x
4	Ажлын байр нэмэгдэх	x				x					x
5	Улирлын чанартай эрэлт, хэрэгцээ нэмэгдэх	x				x					x
Бусад нөлөөлөл											
1	Шороон зам, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх		x				x				x
2	Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал хийгээгүйгээс болж		x				x				x

эвгүй үнэр гарах, шавьж үржих												
Дүн	7	10	17	0	10	7	0	0	0	6	11	

Дээрх хүснэгтээс үзэхэд тэсрэх бодисын үйлдвэрийг цаашид ашиглахад байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг нөлөөллийн чанараар нь авч үзвэл эерэг нөлөөлөл 7, сөрөг нөлөөлөл 10, нөлөөлөлгүй 17, нөлөөллийг зэргээр авч үзвэл бага нөлөөлөл 0, бага зэрэг нөлөөлөл 10, дунд зэрэг нөлөөлөл 7, хүчтэй нөлөөлөл 0, их хүчтэй нөлөөлөл 0, нөлөөллийн үргэлжлэх хугацаагаар нь авч үзвэл урт хугацааны 0, дунд хугацааны 6, богино хугацааны 11 нөлөөлөл болж байна.

Эерэг нөлөөлөл: Нийгэм эдийн засаг талаасаа тус төслийн үйл ажиллагаа хэрэгжсэнээр хүн амын орлого нэмэгдэж, орон нутагт татвар хураамжийн орлого орохоос гадна ажлын байр нэмэгдэж, ядуурлын түвшин буурахад эерэгээр нөлөөлөхөөр байна.

Сөрөг нөлөөлөл: Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын үйл ажиллагаанаас үйлдвэрийн талбайн хөрс, ургамал талхлагдах, тэсрэх бодисыг тээвэрлэх үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт, агаарт ялгарах хорт хий, дуу чимээ зэрэг нөлөөллүүд нь байгаль орчинд шууд нөлөөлж байгаа юм. Эдгээрт төслийн үйл ажиллагаанаас шалтгаалж хөрсний элэгдэл, эвдрэл, ургамлын бүтэц өөрчлөгдөх, ахуйн бохир ус, хог хаягдлын цэгийн ариутгалыг муу хийснээс орчин бохирдох, өвчин гарах, эрдэс түүхий эдийн нөөц багасах, хөрсний бохирдол үүсэх болзошгүй нөлөөллийг үүсгэж байна. Мөн тоосжилтоос үүдэн үйлдвэрийн орчмын ургамлан нөмрөг тоосонд дарагдах, ургамлын өсөлт зогсох зэргээр сөргөөр нөлөөлөх, тээврийн хэрэгслийн дуу чимээ, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх нөлөөлөл, санамсар болгоомжгүйгээс үйлдвэр, агуулахын байранд түймэр гарах зэрэг нөлөөлөл байж болно.

Богино болон дунд хугацааны нөлөөлөл: Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, замын тоос шороо хийсэх, хүнд механизмын хөдөлгүүрийн дотоод шаталт, агаарын хольц зэргээс агаар богино хугацаанд бохирдох, ажиллагсдын эрүүл мэндэд муугаар нөлөөлөх, ойр орчмын хөрс ургамал, бэлчээрийн талбай тоосонд дарагдаж өөрийн унаган төрхөө алдах, ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, ялаа шавьж үржих зэргээр сөргөөр нөлөөлнө.

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Газрын гадарга, Хөрсөн бүрхэвч, Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Газрын гадаргын эвдрэл үүсэх,
- Тээврийн хэрэгсэл болон хүний хөдөлгөөний улмаас хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх, үржил шимийн доройтолт орох,
- Химийн бодис асгарснаас газрын гадарга хөрс бохирдох,
- ШТМ асгарч хөрсний бохирдол үүсэх.
- Ахуйн хог хаягдлаар газрын гадарга, хөрс бохирдох.
- Үйлдвэр, агуулахын суурийн хэсгийн ургамлан бүрхэвч устаж үгүй болох, үйлдвэрээс гарах тоос нь орчны ургамлан бүрхэвчийн бүтцэд нөлөөлж улмаар доройтол үүсгэх.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Тэсрэх бодис, материал зөөх, тээвэрлэх үед үүсэх тоосжилт үүсэх,
- Тэсрэх бодисыг
- Салхитай үед агаарт тоосонцор үүсэх,
- Техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээний нөлөө үүсэх,
- Тээврийн хэрэгслийн яндангаас үүсэх утаа хий тортог гарах,

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Унд ахуйн усыг зориулалтын саванд хадгалаагүйгээс ус бохирдох,
- Ахуйн шингэн хаягдлаар хөрс бохирдох,
- Үер усны нөлөөлөл үүсэх,

Хог хаягдлаас үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Ахуйн хог хаягдал, бохир ус, бие засах газрын ашиглалтаас үүсэх орчны бохирдлын нөлөө,
- Хог хаягдлыг ил задгай хаяснаас үүсэх орчны бохирдол,
- Тэсрэх бодисын сав баглаа боодлыг замбараагүй хаяснаас орчны бохирдол үүсэх.

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:

- Ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үүсэх,
- Ажилчид хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллах,
- Ажилчид тэсрэх бодисын аюулгүй ажиллагааны заавачрилгааг өггөхгүй байх,
- Химийн бодисонд хордож эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх.
- Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлэхгүй байх.

БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Мастер майнинг сервис” ХХК-иас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт:

Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино. Үүнд:

- Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, усны чанарт усанд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох,
- Байгаль орчны төлөв байдалд хяналт тавих хугацаа, хариуцах эзэнг тогтоох,
- Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичгийг тодорхойлох,
- Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно.

“Мастер майнинг сервис” ХХК-ийн 2024 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь уг төслийн үйл ажиллагааг эрхлэн явуулах бүхий л үе шатыг хамрах ба гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж бүхий нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

Зорилго: “Мастер майнинг сервис” ХХК-ийн “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго оршино.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго нь “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг, агуулга:

Байгаль орчны нөлөөлөл байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн (МУ хууль, БОНБУ-ний тухай, 2012) 9 дүгээр зүйлд зааснаар БОМТ нь Байгаль хамгаалах төлөвлөгөө (БХТ), орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ (заалт 9.5). БХТ-нд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана (заалт 9.6). ОХШХ-т төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тодорхойлон тусгана (заалт 9.7).

Хуульд БОМТ-ний хэрэгжилтэнд байгаль хамгаалагч, БО-ны улсын байцаагч, Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, БО-ны ТББ хяналт тавина гэж заасан байна. Үүн дээр тухайн газар нутагт гарч байгаа өөрчлөлтийг хамгийн сайн мэдэх нутгийн ард иргэд болон шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээ, дүгнэлт өгөх мэргэжлийн байгууллагын хяналт зайлшгүй байх ёстой гэж үзэн нэмж оруулсан.

БОМТ-г БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар БОМТ-г боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу боловсруулсан.

Байгаль хамгаалах төлөвлөгөө:

- Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зайлуулах арга хэмжээ
- Нөлөөллийг бууруулах арга хэмжээ
- Ногоон өаыгууламж, цэцэрлэгжүүлэлтийн арга хэмжээ
- Тухайн жилийн БОМТ хэрэлжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ
- Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ
- Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр:

- Нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэл ба төсөл хэрэгжсэнээр түүнд гарч болзошгүй тоон ба чанарын өөрчлөлт;

- Нөлөөллийг багасгах, арилгах, нөхөн сэргээх, хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээний үр дүнг хэмжих тоон ба чанарын үзүүлэлтүүд;
- Төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол улсын хууль тогтоомж, стандарт болон хэм хэмжээний үзүүлэлтүүд;
- Хяналт-шинжилгээ хийх шаардлагатай байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүд, нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн;
- Сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, давтамж;

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүтэц:

БОМТ-ний бүрэлдэхүүнд 5 бүлэг, 8 ерөнхий хэсэгтэй.

1. Оршил
2. Төслийн танилцуулга
3. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга
4. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
5. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ
6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө: Энэ хэсэгт Байгаль хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдийг тус бүрээр нь шийдэл болон тэдгээрийг хэрэгжүүлэхийн тулд авах арга хэмжээ, явуулах үйл ажиллагаа, хариуцах эзэн, хугацаа, төсөв зэргийг нэгтгэн хүснэгтийн хэлбэрт оруулан тайлбарласан.
7. Дүгнэлт
8. Ашигласан хэвлэл

БҮЛЭГ 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг /2024 он/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын орчин									
1	- Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үед гарах тоосжилт,	Хуурайшилт болон салхи ихтэй үед үйлдвэрийн зам талбайг услаж чийглэж байх.	Зам талбай	-	-	-	Дотоод төлөвлөлт-өөр	Хуурайшилт-тай үед тогтмол	
2	- Тээвэрлэлтийн хөдөлгөөний үед үүсэх тоосжилт, -Тээврийн хэрэгсэлийн яндангаас ялгарах утаа, хорт хий бодисуудаар орчны агаар бохирдох.	Тэсэлгээний бодис тээвэрлэх тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн тохиргоо үйлчилгээг тогтмол хийх, стандартын түвшинд байлгах	Тээврийн хэрэгсэл	-	-	-	100,000	2024 онд	
3		Тээврийн хэрэгслийг жил бүр үзлэгт хамруулж, агаарын бохирдлын төлбөрийг төлөх, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг хийх.	Тээврийн хэрэгсэл	-	-	-		2024 онд	
4	- Хог хаягдлаас үүсэх агаар орчинд эвгүй үнэр үүсэх.	Тэсэлгээний бодисыг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэрээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй нөхцөлд хадгалах.	Тэсэлгээний бодис	-	-	-	-	Тогтмол	

Газрын гадарга									
1		Газар ашиглалтыг зөвхөн батлагдсан зураг төслийн дагуу явуулах		-	-	-	-	Тогтмол	-Газрын тухай хууль
2	Газар ашиглалтыг зөв зохистой ашиглаагүйгээс үүсэх нөлөөлөл	Газрын төлбөрийг цаг тухайд нь төлөх	Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах	-	-	-	-	2024 онд	
3		Үйлдвэрийн эзэмшил газрыг тогтмол цэвэрлэж байх, хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх		-	-	-	-	Тогтмол	
Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг									
1	-Тээвэрлэлтийн үед олон салаа зам гарч хөрс элэгдэл эвдрэлд өртөх, ургамлан нөмрөг тадхлагдах, -Тэсэлгээний бодис тээвэрлэх үед бодис алдагдаж хөрсийг бохирдуулах, - Шатах тослох материал асгарснаас хөрсөн бүрхэвчийг бохирдуулах, -Хөрс хатуу хог хаягдлаар бохирдох.	Тэсэлгээний бодисыг хүлээн авах, тээвэрлэх, хадгалах, түгээх, хэрэглэх үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс бодис алдагдаж, газрын гадарга болон хөрсийг бохирдуулах	Газрын гадарга, хөрсөн бүрхэвч	-	-	-	-	Тогтмол	-Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд: MNS3298-91, -Хөрс-агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох: MNS3310-918, -MNS5850-2008, “ Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
2		Үйлдвэр, агуулах орчмын зам талбайг засч тохижуулах	Зам талбай	-	-	-	Дотоод төлөвлөлт-өөр	2024 онд	
3		Тээврийн хэрэгслийн зам талбайн зорчих хэсэгт таних тэмдгийг сайжруулах, нэмэгдүүлэх	Таних тэмдэг	-	-	-	100,000	2024 онд	
4		ШТМ хөрсөнд асгарсан тохиолдолд нэн даруй саармагжуулах арга хэмжээ авах	ШТМ	-	-	-	-	Тогтмол	

5		Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг зориулалтын хатуу хучилттай талбайд хийх.	Засвар үйлчилгээний талбай	-	-	-	-	Тогтмол	
Усан орчин									
1	-Унд ахуйн усны чанар муудах, -Зуны улиралд үер усны аюул үүсэх.	Үйлдвэрийн үерийн хамгаалалтын даланг засч сайжруулах	Үерийн хамгаалалт	-	-	-	-	Үйл ажиллагаа-ны зардалд тусгагдсан.	-Усны тухай хууль, -Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, -“Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998.
2		Унд ахуйн ус нөөцлөх зориулалтын сав нэмэгдүүлэх	-	-	100,000	1	100,000	2024 онд	
3		Унд ахуйн усанд усны чанарын хяналтын шинжилгээ хийлгэж, унд ахуйн стандартад нийцүүлэх	Унд ахуйн ус	-	-	-	-	ОХШ-Хөтөлбөрт тусгагдсан	
Нийт								300,000	

6.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Хүснэгт 7. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг /2024 он/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Үйлдвэрийн талбайн эргэн тойронд ногоон байгууламж бий болгох, арчилж, хамгаалах	Үйлдвэрийн хашаанд мод тарьж, ногоон байгууламж бий болгох.	-	-	-	1,000,000	2024 онд	-MNS 6140:2010, Мод, сөөгний тарьц. Техникийн шаардлага, -MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” -MNS 5918:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага”
2	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд	ш	50	-		2024 онд	

	хүрээнд мод бут тарих	орон нутгаас тогтоосон газарт мод тарих						-MNS 5978:2008 “Байгаль орчин, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт”
3	Мод бут, зүлэгжүүлэлтийн арчлалт хамгаалалт	Мод бут тарьсан газрыг арчлан хамгаалах, тордох, услаж байх.	-	-	Дотоод төлөвлөлтөөр	2024 онд		
	Нийт					1,000,000		

6.3. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Үйлдвэрийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвор илрээгүй учир түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө хийгдэхгүй.

6.4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг /2024 он/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	-Болзошгүй аюул осол саатал гарах, техник технологийн шугам сүлжээний гэмтэл гарах,	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	-	-	-	-	Тогтмол	-Гамшгаас хамгаалах тухай хууль, -MNS 6010-2009 Гамшгийн холбогдолтой нэр томъёо тодорхойлолт, ерөнхий анги. -Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль.
2	-Галын гэнэтийн аюул үүсэх, -Тэсрэх бодисын асгаралт, тээвэрлэлт зэргээс орчны бохирдол үүсэх.	Галын аюулаас хамгаалах багаж хэрэгсэлийг бэлэн байлгах, шаардлагатай тохиолдолд нэмэгдүүлэх	Галын аюулаас сэргийлэх багаж хэрэгсэл	-	-	-	200,000	2024 онд	
3		Ажлын байранд гал гаргахыг хатуу хориглосон анхааруулга тэмдэглэгээг шинэчилж сайжруулах	Анхааруулах самбар	-	-	-	100,000	2024 онд	

4	Тэсэлгээний бодистой холбоотой үйл ажиллагаа явуулах өрөө тасалгаа, агуулахад хоорондоо үл зохицох (хамтад нь хадгалж болдоггүй) бодисуудыг хамт хадгалахгүй байх.	Тэсэлгээний бодис	-	-	-	-	Тогтмол
5	Тэсрэх бодисын хадгалалт хамгаалалтын аюулгүй ажиллагааны дүрмийг сахих, алдагдах нөхцлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах хяналт байнга тавих	-	-	-	-	-	Тогтмол
6	Тэсэлгээний бодисын нэг агуулахад 500 тонноос, агуулахын доторхи нэг тасалгаанд 50 тонноос ихгүй бодис хадгалах ялангуяа шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, системээс хол, шууд нарны гэрэл тусахааргүй, үер усанд автахааргүй нөхцөлд хадгална	Тэсрэх бодис	-	-	-	-	Тогтмол
7	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулах	Ажилчдад	-	-	-	200,000	2024 онд
8	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслэлээр (ажлын хувцас, өвөл, зуны гутал, хамгаалалтай нүдний	Ажилчдад	-	-	-	300,000	2024 онд

		шил, бээлий, чих бөглөгч г.м) хангах							
9		“Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль, “Химийн хорт болон аюултай бодисыг импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх худалдах журам”, “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх ашиглах устгах журам”, зэрэг хууль, журам тогтоол дүрэм зэргийг нарийн баримталж ажиллах.	Ажилчид	-	-	-	-	Тогтмол	
Нийт							800,000		

6.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах, арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг / 2024 он /	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хог хаягдал	Ахуйн хатуу хог хаягдлын зориулалтын ангилан ялгах хогийн савыг сайжруулах, нэмэгдүүлэх.	Хог хаягдал	ш	100,000	1	100,000	2024 онд	-Хог хаягдлын тухай хууль /2017.05.12/ - MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
2		Хогийг нэгдсэн нэг цэгт төвлөрүүлэх, Хог хаягдлын цэгийг хашаажуулах.	Хог хаягдал	-	-	-	150,000	2024 онд	
3		Хог хаягдлын гэрээг орон нутагтай байгуулж, тогтмол тээвэрлүүлэх	Хог хаягдлын гэрээ	-	30,000	12	360,000	Сар бүр	
4	Үйлдвэрийн	Төслийн үйл ажиллагаанаас гарч байгаа дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж, хоёрдогч түүхий эдийн цэгт тушаах	Дахин ашиглах боломжтой хог хаягдал	-	-	-	-	Сар бүр	
5	Аюултай хог хаягдал	Тэсрэх бодисын уут, сав баглаа боодлыг зориулалтын стандартын шаардлага хангасан цэгт төвлөрүүлэн хадгалах	Тэсрэх бодисын сав баглаа боодол	-	-	-	-	Тогтмол	
6		Тэсрэх бодисын сав баглаа боодлын хаягдлыг “Цэцүүх трейд” ХХК-тай гэрээ байгуулж, гэрээг сунгаж, гэрээнд тусгагдсаны дагуу устгуулах.		-	-	-	“Цэцүүх трейд” ХХК-тай гэрээ байгуулсны дагуу	2024 онд	
		Нийт					610,000		

6.6. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			1-4-р сар	5-8-р сар	9-12-р сар		
1	Ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	200,000		+		“Мастер майнинг сервис” ХХК	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж байх шаардлагатай.
2	Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх	Мэргэжлийн байгууллагатай тохиролцох		+		“Мастер майнинг сервис” ХХК	Байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэх
3	Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгаа хийлгэх	Мэргэжлийн байгууллагатай тохиролцох		+		“Мастер майнинг сервис” ХХК	Газрын тухай хуулийн 58-р зүйл Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам
4	Орон нутагтай нягт хамтарч ажиллах, орон нутгаас тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх	Дотоод төлөвлөлтөөр	+	+	+	“Мастер майнинг сервис” ХХК	Орон нутагтай хамтран ажиллах
Нийт		200,000					

6.7. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө

Хүснэгт 11. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Нийслэлийн байгаль орчны газарт	Тайлан хэлбэрээр, албан бичиг	БОМТ-ий хэрэгжилтийн талаар	11-р сард	-	“Мастер майнинг сервис” ХХК	Нийслэлийн байгаль орчны газарт
2	БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин бодлого зохицуулалтын газар	Тайлан хэлбэрээр, албан бичиг	БОМТ-ний хэрэгжилтийн тайлан болон тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	11 сард	-	“Мастер майнинг сервис” ХХК	БОАЖЯ

6.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг /2024 он/	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаарын орчин								
1	Тоосжилт: / PM10, PM _{2.5} , TSP / Агаарын бохирдол: / CO ₂ , SO ₂ , NO ₂ /	Үйлдвэр агуулахын орчмоос	Жилд 1 удаа	1 цэг	Агаарын шинжээч-100,000 Агаарын сорьц дээж-30,000	280,000	Агаарын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэх	-MNS 5885 : 2008, Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага -MNS 5013:2003 Бензин хөдөлгүүртэй автомашины, утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга -MNS 5014:2003 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын

							зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга	
Хөрсөн бүрхэвч								
2	-Хөрсний агрохими. / Нийт азот. Хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат гэх мэт /	Үйлдвэр агуулахын орчмоос 2 цэг	Жилд 1 удаа	2 цэг	Хөрсний агрохимийн шинжилгээ 1дээж-25,000	50,000	Итгэмжлэгдсэн хөрсний лабораторид шинжлүүлэх.	-MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, -MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох арга -MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага -MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох.
	-Хөрсний хүнд металл. / Кадьми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр /	Үйлдвэр агуулахын орчмоос 1 цэг	Жилд 1 удаа	1 цэг	Хүнд металлын шинжилгээ 1дээж– 25,000	25,000		
Усан орчин								
1	Усны ерөнхий химийн шинжилгээ: / рН, TDS (нийт ууссан давс), нийт хатуулаг (CaCO ₃), ууссан хүчилтөрөгч, БХХ, ХХХ, Са, Mg, Na, К, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ -ны агууламж, амт, үнэр, өнгө /	Унд ахуйд хэрэглэж буй уснаас	Жилд 1 удаа	1 дээж	Усны ерөнхий шинжилгээ 33,000	33,000	Усны итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх	-MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага -MNS 13.060.50 Усны чанарын стандарт, -MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл Усны түвшин (газрын гадаргаас ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Нийт						388,000		

2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

“МАСТЕР МАЙНИНГ СЕРВИС” ХХК-ийн 2024 оны БОМТ-ний тайланг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

2024 онд БОМТ-нд нийт **3,298,000.0** төгрөг зарцуулахаар төлөвлөвөө.

Хүснэгт 13. 2024 оны БОМТ-нд зарцуулах нийт зардал

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2024 он /төгрөг/
1	Байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	300,000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1,000,000
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	610,000
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	800,000
6	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	200,000
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	388,000
Нийт дүн		3,298,000

ДҮГНЭЛТ

Улаанбаатар хотын Багахангай дүүргийн нутагт орших “Мастер майнинг сервис” ХХК-ийн “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг боловсрууллаа.

“Мастер майнинг сервис” ХХК-ийн 2024 оны БОМТ-ний тайланг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хянан үзэж, батлуулж байх шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2024 онд нийт 3.3 сая.төг зарцуулахаар төлөвлөлөө.

“Мастер майнинг сервис” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ны дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

“Мастер майнинг сервис” ХХК нь жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль экологийн унаган төрхийг хамгаалахын тулд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүн, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж зэргийг дагаж мөрдөж ажиллах шаардлагатай.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” БОАЖСайдын А/618 тоот тушаал, 2019 он.
5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал 2014
6. Улаабаатар хотын Багахангай дүүргийн нутагт орших “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2022 он
7. Улаабаатар хотын Багахангай дүүргийн нутагт орших “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”-ын төслийн БОМТ, 2023 он
8. <http://www.legalinfo.mn/>
9. www.met.gov.mn
10. ArcGIS 10.8